



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/751

Арвайхээр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр суманд нийтийн тээврийн автобус нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Н.Ганболд -Аймгийн Засаг даргын дэргэдэх

Орон нутгийн өмчийн газрын дарга

Нарийн бичгийн дарга: Т.Эрдэнэсүрэн -аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын ажил худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Б.Мөнхбат -аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

В.Ганцэцэг -аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ахлах мэргэжилтэн

Ш.Авирмэд -Бүтээлч хөгжлийн хөтөч ТББ-ын гишүүн (зөвшилцсөнөөр)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Н.Ганболд)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж архив-бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Т.Эрдэнэсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД

011101636

D:My Doc. Zahiramj. Zasag darga